



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар A/87

Бүрэн сум

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан
сэргийлэх вакцинуулалтын ажлыг эхлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалт, Төв аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн A/273 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ноос 05 дугаар сарын 12-ны өдрийн хороонд зохион байгуулсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг тарих малчин өрхийн жагсаалтыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж бүрээр гаргах, хүйтэн хэлхээний идэвхийг нь бууруулахгүй байхад онцгой анхаарч, мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр ханган, дархлаажуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Н.Хүрэлбаатар)-д үүрэг болгосугай.

3. Малчин, мал, амьтан маллагч өмчлөгчдөд дархлаажуулалтын товыг зарлан мэдээлж, дархлаажуулалтад хамрагдах малыг бүрэн бэлдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг ханган, малчнаар малыг барьж бэхлүүлэн тарилгыг гүйцэтгүүлэх талаар малчдад мэдээлэл хүргэн ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Дархлаажуулалтын мэдээг Мал эмнэлгийн нэгдсэн системд тухай бүр оруулах, дархлаа тогтох хүртэлх 28 хоногийн хугацаанд гарал үүслийн гэрчилгээ бичихгүй байх, өрхийн дэвтэрт хөтлөлт хийж баталгаажуулж ажиллахыг “Түмий” ХХК, “Баясгалан-Уул” ХХК, “Сайн цохио” ХХК, “Арцат баянгүн” ХХК, “Баялагсүрэг баянтөхөм” ХХК –ний малын эмч (Д.Цэрэндаваа, Б.Дэлгэрнасан, Д.Хасбазар, Л.Сарантуяа, Д.Оюунтуяа) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Пүрэв-Очир)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Т.ТУВШИНБАТ



412305199